АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
НИЙТИЙН НОМЫН САН

2022.10.24

| № | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Түвшин | | |
| Бодлогын баримт бичгийн зорилго 2.6 : Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ. | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ: 2.6.3. Соёл, урлагийг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | Арга хэмжээний тоо | 2021 | 3 | 4 | “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” “Илүү их уншъя”, “Номын баяр”-ын хаврын үйл ажиллагааг 2022 оны 05 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд 12-н төрлийн арга хэмжээг зохион байгуулж 4.496.416 мянган төгрөг зарцуулсан. 2541 иргэд, уншигчид хамрагдсан.<br><br>“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” “Илүү их уншъя”, “Номын баяр”-ын намрын үйл ажиллагааг 2022 оны 09 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд 16-н төрлийн арга хэмжээг зохион байгуулж 6.003.584 мянган төгрөг зацуулсан. 2836 уншигч, иргэд оролцсон.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Үйл ажиллагааны тоо– 2<br>Арга хэмжээний тоо - 28<br>Хамрагдсан иргэдийн тоо – 5377<br>Зарцуулсан зардал- 10.500.000 Үүнээс:<br>Дээд шатны байгууллагаас хуваарилсан 10.000.000<br>Аймгийн Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээний зардлаас 500.000<br><br>**Хэрэгжилт 100%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ: 2.6.4. Хөдөөгийн багийн иргэдэд явуулын соёлын үйлчилгээг үзүүлнэ. | | Үйлчилгээний тоо<br><br>Хамрагдах хүний тоо | 2021 | 1<br><br>50 | 1<br><br>73 | Хөдөөгийн 4,5,6 дугаар багын иргэдэд 2022 оны 05 сарын 04, 05, 06-ны өдрүүдэд нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэсэн. Үүнд:<br>Байгууллагын үйл ажиллагааг сурталчилан таниулж, шинээр 44 уншигчид карт нээж, 75 ширхэг шинэ номын танилцуулга хийж үзэсгэлэн гаргасан.<br>Танин мэдэхүйн “АХА” цэнгээнт тэмцээнийг зохион байгуулсан. 4,6 дугаар багийн 52 иргэн оролцсон.<br>Байгууллагын талаарх санал асуулгыг 32 иргэнээс авсан.<br>**160 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.**<br><br>2022 оны 06 дугаар сарын 16-ны өдөр “Хөдөөгийн баясгалан” багийн өдөрлөгт оролцож байгууллагын танилцуулга брюшур 220 тарааж, 68 ширхэг шинэ номоор үзэсгэлэн гаргасан.<br><br>С.Буяннэмэхийн нэрэмжит “Таван хором” шүлгийн уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулж 27 иргэд оролцсон.<br><br>**Өдөрлөгт нийт 248 иргэдэд үйлчилгээ үзүүлсэн.**<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Нүүдлийн номын сангийн үйлчилгээний тоо - 2<br>Хамрагдсан иргэдийн тоо - 408<br>Зарцуулсан зардал –217.500 Үүнээс: шатахуун 97500, шагнал 120.000<br><br>**Хэрэгжилт 100%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Арга хэмжээ: 2.6.5. Орон нутагт соёл, урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулна. | | Сургалтын тоо | 2021 | 1 | 3 | Аймгийн Нийтийн Номын сан нь Удирдах ажилтан-1, Гүйцэтгэх ажилтан-6, үйлчлэх ажилтан-3, нийт 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан.<br><br>Соёлын яам, СУИС-ийн Соёлын дээд сургуулиас зохион байгуулсан Лавлагаа ном зүйн кредит олгох, Дижитал маркетингийн мэргэжил дээшлүүлэх цахим сургалтад 5 албан хаагч<br><br>Үндэсний номын сангаас зохион байгуулсан Тогтмол хэвлэлийн улсын нэгдсэн санд орон нутгийн гаргасан тогтмол хэвлэлийг бүртгэж оруулах 2 удаагийн сургалтад 2 албан хаагч,<br><br>2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр ERP.E-Mongolia.mn цахим сургалтад 7 албан хаагч<br><br>"NEW STORY" хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Соёлын яамтай хамтарсан сургалтад 2 албан хаагч хамрагдаж Говьсүмбэр аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүнээр сонгогдсон.<br><br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан ХНУМТ системийн сургалтад 2 албан хаагч,<br>Корнавирист халдвар /ковид-19/-ийн тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам,<br>Манлайллын хэв маяг, хандлага тодорхойлох нь,<br>Алдаа дутагдлыг шийдвэрлэх сургалтуудад 7 албан хаагч |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Авлигалтай тэмцэх газраас зохион байгуулсан 21 аймгийн шинээр томилогдсон албан тушаалнуудад зориулсан авлигын эсрэг анхан болон дунд шатны сургалтад 7 албан хаагч,<br>Таны эрх таны оролцоо авлигалд үгүй гэж хэлье иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх сургалтад 10 албан хаагч,<br>Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс “Харилцаа хандлага ёс зүйн сэдвээр<br><br>Хууль эрх зүйн хэлтсээс Авлигын тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчлийн тухай хууль<br>Онцгой байдлын газраас “Галын аюулгүй байдал”,<br>“Хувь хүний хөгжил ба хандлага, сэтгэлгээний өөрчлөлт”,<br>“Амар амгалан Говьсүмбэрийн төлөө”,<br>Боржигин Өв Музейгээс Угийн бичгийн сургалт зэрэг байгууллагаас болон бусад мэдлэг, чадвар, чадамж нэмэгдүүлэх богино хугацааны сургалтанд албан хаагчдыг 100% хамруулан ажилласан.<br><br>5 албан хаагч 6 өдрийн 30-н төрлийн хичээлийн онлайн сургалтад хамрагдаж шалгалт өгч сертификат авсан.<br><br>Аюулгүй байдал хамгаалалтын академийн Хамгаалалтын ажилтан бэлтгэх “Очир” сургалтын төвд 210 цагийн сургалтад 2 албан хаагч хамрагдаж сертификат авсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтын тоо-18<br>Хамрагдсан албан хаагч – 10<br>Зарцуулсан зардал- 400,000<br><br>**Хэрэгжилт 100%** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Арга хэмжээ: 2.6.6. Соёл, урлагийн байгууллагуудын орчин, нөхцөлийг сайжруулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана. | | | | | | Орчин нөхцөлийг сайжруулж техник тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд:<br><br>**Төсвийн хөрөнгөөр:**<br>Ном ариутгагч төхөөрөмжийг “Боржигин нутаг BNZ” ХХК-тай гэрээ байгуулан 2,500,000 мянган төгрөгөөр захиалан авч фондын сан хөмрөгийн ном хэвлэлийг ариутган иргэд, уншигчдад хүргэн үйлчилж байна.<br><br>Superlead 3300 бар код уншигчийг “Электромон Трейдин” ХХК-аас 330.000 мянган төгрөгөөр худалдан авч уншлага үйлчилгээнд ашиглаж байна.<br><br>**Хөрөнгө оруулалтаар**:<br>“Монгол соёл- Монгол хүмүүн” төсөл хөтөлбөрийн хүрээнд 1,932,006 мянган төгрөгийн зөөврийн “DELL core i5” компьютер ирсэн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Тоног төхөөрөмжийн тоо- 3<br>Зардал, мөнгө- 4,762,006<br><br>**Хэрэгжилт 100%** |
| 5 | Арга хэмжээ: 2.6.7.7 Төрийн байгууллагын албан хаагчдыг Монгол бичгийн сургалтад хамруулж, хуучин Монгол бичгээр унших, бичих чадавхыг | | Сургалтанд хамрагдсан албан хаагчдын хувь | 2021 | 0 | 100 | Нийт албан хаагчдад Монгол бичгээр бичиж, унших дадлага сургалтыг өдөр бүр хийж хэвшсэн.<br><br>Л.Лоохууз багшаар монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтуудыг 3 удаа танхимаар авсан.<br><br>Говьсүмбэр номынз сан монгол бичгийн хичээлийн групп чат нээж өдөр бүр Л.Лоохууз багшаар хичээл заалган даалгавар авч даалгаварыг “Чойр номын сан” группд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулж, албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулж эхэлнэ. | | | | | | байршуулан Ном зүйч А.Чимэгмаа шалгаж хэвшсэн.<br><br>Албан хаагчид монгол бичгээ сурахад Э.Олонцэцэг багшийн гаргасан Үндэсний бичгээ шамдан сурцгаая-1 номыг ашиглаж байна.<br><br>14 хоног тутамд Монгол хэлний бодлогын салбар зөвлөл, Соёл, урлагийн газарт монгол бичгийн тайланг хүргүүлэн ажиллаж байна.<br><br>Монгол бичгийн ахисан шатанд А.Чимэгмаа, Б.Аасүрэн, нар компьютер болон чимээ апп-р ертөнцийн гурав, эрдэнийн сан, субашидаас өдөр бүр бичин суралцаж байна.<br><br>Байгууллагаас зохион байгуулж байгаа ном уншлагын аян болон цаг үеийн мэдээллийг “Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан” пэйж хуудсанд хос бичгээр бичин байршуулж байна.<br><br>Монгол бичгийн самбарыг “Уран бичлэг”, “Зүйр онч үгс”, Ойролцоо утгатай үг”, Шинэ мэдээ, мэдээлэл”, “Монгол бичгийн дүрэм” гэж ангилан мэдээллийг Монгол бичгээр мэдээлж, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны бүртгэлийг хос бичгээр бичсэн.<br><br>Албан хаагчдын өрөөний хаягийг болон энгэрийн тэмдэгийг монгол бичгээр бичсэн.<br><br>Уншигч, номыг уншиж байгаа хэсэгтээ нугалах, тэмдэглэж муухай болгохоос хамгаалах уншигчдын монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, бататгах зорилгоор “НОМЫН ХАВЧУУРГА”-ыг уншигч, хүүхэд багачууд, иргэдэд зориулан 2 төрлөөр номтой холбоотой зүйр цэцэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үг уриалсан сургамжит мэдээлэл зэргийг монгол бичгээр бичиж бэлтгэн 300 ширхэгийг шинээр ирсэн номонд хийж байрлуулсан.<br><br>“Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан” цахим хуудсуудаар дамжуулан өглөөний мэндчилгээ, онч мэргэн үгсийг хос бичгээр байршуулж иргэдэд хүргэж байна.<br><br>Монгол бичгийг иргэдэд сурталчлах түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>Монгол Улсын гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит 19 дэх удаагийн “Бичиг Соёл минь-2022” монгол хэлний бүсийн олипадид Байгууллагын төрөлд хамт олоноороо оролцсон. Ном зүйч А.Чимэгмаа иргэний төрөлд оролцож “Дэд байр” эзэлсэн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Сургалтын тоо- 3<br>Хамрагдсан алба хаагчдын тоо-10<br>Хувь- 100%<br>**Хэрэгжилт 100%** |
| 6 | Арга хэмжээ: 2.6.7.8 Монгол бичгийг иргэдэд сурталчлан түгээн дэлгэрүүлнэ. | | Арга хэмжээний тоо | 2021 | 1 | 2 | Говьсүмбэр аймгийн “Соёл урлагийн газар” “Нийтийн Номын сан”-гаас хамтран “МОНГОЛ БИЧГИЙН ЦАХИМ БИЧВЭР 2022” уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, төрийн албан хаагчид, иргэдийн дунд 2 үе шаттайгаар зохион байгуулсан нийт 31 иргэд, сурагчид оролцсон.<br><br>Монгол бичгийн номын үзэсгэлэнг цахимаар зохион байгуулж 96-н иргэд уншигчид хамрагдсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хүрсэн түвшин:**<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо-2<br>Хамрагдсан иргэдийн тоо-127<br>Зарцуулсан зардал-345.000<br>**Хэрэгжилт 100%** |
| 4.1 “**Цахим Монгол- төрийн шуурхай үйлчилгээ:** | | | | | | | |
| 7 | Арга хэмжээ: 4.1.2.3 Төрийн үйлчилгээнд ХУР, ДАН систем, тоон гарын үсгийг нэвтрүүлнэ. | | ХУР, ДАН системд тоон гарын үсгийг нэвтрүүлсэн албан хаагчдын тоо | 2021 | 0 | 10 | 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Төрийн үйлчилгээг цахимжуулах ХУР, ДАН, e-mongolia системийн сургалтанд 7 албан хаагч хамрагдсан. e-mongolia системд 10 албан хаагч бүртгүүлэн ашиглаж байна.<br>Төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын дарга, нягтлан бодогч нар 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр тоон гарын үсэг авсан.<br>2022 оны 07-08 дугаар саруудад 10 албан хаагч тоон гарын үсэг авч эзэмшсэн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Хур, Дан систем нэвтрүүлсэн албан хаагчийн тоо-10<br>Тоон гарын үсэг нэвтрүүлсэн албан хаагчийн тоо-10<br>Зарцуулсан зардал-50.000<br><br>**Хэрэгжилт 100%** |
| 8 | Арга хэмжээ: 4.1.3.5 Төрийн цахим санг өргөтгөн төрийн байгууллагуудад | | ERP системийг бүрэн нэвтрүүлж, ашиглаж буй албан хаагчдын тоо<br><br>Хэрэгжилтийн хувь | 2021 | 0 | 10<br><br>100% | 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр админ эрх авч байгууллагын 10 албан хаагчдыг бүртгэн ERP системийг нэвтрүүлэн ажиллаж байна.<br>ERP системийн 10 цэсийг бүрэн ашиглаж, албан хаагчдад үүрэг даалгавар өгч, албан бичиг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлнэ. | | | | | | шилжүүлэх, ирсэн явсан бичгийг тогтмол хүлээн авч, ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэн ERP системээр явууж байна.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>ERP системийг нэвтрүүлсэн албан хаагчдын тоо-10<br><br>**Хэрэгжилт 100%** |
| 9 | Арга хэмжээ: 4.1.3.6 Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | | Цахим сайтад байршуулсан ил тод мэдээллий тоо | 2021 | 0 | 12 | Мэдээллийн ил тод, байдлыг хангах арга хэмжээнд:<br>Байгууллагын цахим хуудасны шинэчлэлийг засгийн газрын 374-р тогтоолын 9 дүгээр хавсралтын дагуу:<br>• Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал<br>• Хүний нөөцийн бодлогын ил тод байдал<br>• Төсөв, санхүүгийн ил тод байдал<br>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал зэрэг ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хийлгэсэн.<br>Library.gs.gov.mn цахим хуудсанд 62 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 7798 хандалт авсан байна.<br>Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын сангийн пэйж хуудсанд 461 мэдээ байршуулж, давхардсан тоогоор 11183 иргэд, уншигчид хандалттай.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Цахим хуудас- 62 мэдээ, 7798 хандалт<br>Олон нийтийн сүлжээнд- 461 цахим ном, 11183 хандалт<br>Зарцуулсан зардал- 700.000 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Хэрэгжилт 100%** |
| 10 | Арга хэмжээ: 4.1.3.7 Тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэнэ. | | Өргөдөл гомдлын тоо<br><br>Цахимаар өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн хувь | 2021 | 0 | 10<br><br>100% | Бичгээр 20 өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Бичгээр хүлээн авсан өргөдөл гомдлоо цахимжуулж ERP системд бүртгэсэн.<br>Цахимаар өргөдөл гомдол, санал хүсэлт ирээгүй болно.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Хүлээн авсан өргөдөл, гомдлын тоо- 20<br>Шийдвэрлэлтийн хувь-100 хувь<br><br>**Хэрэгжилт 100%** |

| **Зохицуулалтын салбар** | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Арга хэмжээний тоо** | **Үүнээс** | | | | | | | **Хугацаа болоогүй** | **Тасарсан** | | **Биелэлтийн хувь** |
| | **Биелсэн** | **Хэрэгжих шатандаа** | | | | | | | **Зохион байгуулалтаас** | **Хөрөнгийн эх үүсвэр дутагдсанаас** | |
| | | 90% | 70% | 50% | 30% | 10% | 0% | | | | |
| 10 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | **100** |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
САН ХӨМРӨГЧ, ХҮНИЙ НӨӨЦ М.АЮУШЖАВ

ХЯНАСАН:
ЗАХИРАЛЫГ ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРНАЙ